



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 02

Сүхбаатар сум

Дотоод аудитын хорооны хоёрдугаар хуралдаан

Дотоод аудитын хорооны хурал 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагаас Засаг даргын хурлын өрөөнд эхэлж 12:00 цагт дуусав. Хурлын ирц 75 хувьтай хуралдав.

Хуралд:

Дарга:	Н.Лхагвадорж
Нарийн бичгийн дага:	Т.Мөнхзул
Гишүүд:	Ө.Сувдаа
	Т.Одсүрэн
	Х.Мөнхжаргал
	А.Дашбат

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх
2. Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгийн тухай
3. Шилэн дансны тухай хуулийн 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүнгийн тухай
4. Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийсэн Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай
5. Иргэнээс Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ойн хандивын зарцуулалтай холбоотой гаргасан гомдолд дурдсан асуудлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай
6. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах саналын танилцуулга,
7. Сайхан сумын Хот тохижуулах газрын даргын үйл ажиллагаанд албан хаагчдаас гаргасан гомдолд дурдсан асуудлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай.

**СОНССОН НЬ:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Т.Одсүрэн хэлэлцэх асуудлын хүрээнд мэдээллийн дарааллын дагуу танилцуулгыг хийв. Үүнд:

**1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагаанд дүгнэлт өгөх**

Т.Одсүрэн: Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 бүлэг, 23 арга хэмжээтэйгээр боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг тайлагнахад бүрэн хэрэгжсэн 15, дутуу хэрэгжсэн 7, огт хэрэгжээгүй 1 дундаж үнэлгээ 87.6% хувьтай тайлагнагдсаныг Хяналт, шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хийсэн үнэлгээгээр 81.7 хувьтай үнэлсэн. Тус үнэлгээний дүнгээр баталгаажуулах саналтай байна.

А.Дашбат: Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн үнэлгээгээр танай байгууллагын үйл ажиллагааг дүгнэх нь өрөөсгөл ойлголт байх учир нь танай байгууллагын үндсэн чиг үүрэг болох хяналт шалгалтын үр дүнг үнэлэх нь дотоод аудитын хорооны зорилготой нийцэхгүй байна.

Т.Одсүрэн: Зарчмын хувьд санал нэг байна. Гэвч хөндлөнгийн хяналт шалгалтаар ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг дүгнээгүй, дотоод аудитын хороо нь дүрмээр заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй гэсэн зөрчил заагдаж байсан тул шинээр байгуулагдсан хороо үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байгаа дээр хяналтын тогтолцоог сайжруулах асуудлыг зөв өнцгөөс нь харж бодлогын түвшинд шийдвэр гаргуулаад явах саналтай байна.

Ө.Сувдаа: Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн үнэлгээгээр тухайн албаны хяналт шалгалтын үндсэн чиг үүргээс гадна бусад асуудлыг үнэлж байгаа тийм учраас цаашдаа үндсэн чиг үүргийн хяналт шалгалтын аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэж байх нь зүйтэй байх.

Х.Мөнхжаргал: гишүүдтэй санал нэг байна. дотоод аудитын хороогоороо ТЕЗ-ийн дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, хийгдсэн хяналт шалгалтын тэмдэглэл, аудитын тайлангийн дүнг баталгаажуулах, илрүүлсэн асуудлын хэрэгжилтийн явцтай танилцах, санал зөвлөгөө замаар шийдвэр гаргаад явах нь зүйтэй.

Т.Одсүрэн: Энэ удаадаа өнгөрсөн оны үйл ажиллагааны үр дүнг дээрх үнэлгээгээр баталгаажуулаад цаашид аудитын хорооны гишүүдээс тус албаны Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үндсэн үйл ажиллагааны үр дүн, хяналт шалгалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд авах арга хэмжээнд санал зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангахад удирдлага болгон ажиллахыг шийдвэрлэхийг дэмжиж байна.

Гишүүд: Санал нэгтэй байна.

**2. Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгийн тухай.**

Т.Одсүрэн: Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь хэсгийн үндэслэн аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 тоот удирдамжийн хүрээнд 17 сумын Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэн тайланг танилцуулж байна.

Тус аудитын хяналт шалгалтын үр дүнгээр 17 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын илэрсэн зөрчил дутагдал нь “Их” эрсдэлтэй сангийн хөрөнгийн 56.1 хувь нь чанаргүй зээлийн ангилалд орсон хугацаа хэтэрсэн зээлийн авлагын дүнгээс хамаар төс сангийн үйл ажиллагааг “Хангалтгүй” гэсэн дүгнэлт гарсан.

Х.Мөнхжаргал: албаны даргын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн асуудлыг харахад санхүүгийн бүртгэл тайлагнал албан тушаалтнуудын хариуцлагагүй байдлыг таслан зогсооход хорооны зүгээс дэмжиж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна.

А.Дашбат: Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн дүнг сонсоход үр дүнтэй хяналтын тайлан гарсан байна гэж дүгнэж байна. Хамгийн гол зөрчил илрүүлж болно харин түүнийг засаж залруулах, сахилга хариуцлагыг сайжруулах сангийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд илэрсэн зөрчилтэй асуудлыг таслан зогсооход улсын байцаагчийн гаргасан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг тооцож ажиллахад танай байгууллага сайтар анхаарах нь зүйтэй байна.

Т.Одсүрэн: Хяналтын үр дүнг бодит үр дүнд хүргэхийн тулд шийдвэрийн хэрэгжилтэд хяналтыг сайжруулах чухал ажил байгаатай санал нэг байна.

Шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг сайтар хангуулснаар хийгдсэн аудитын чанар, үр өгөөж дээшлэх давуу сайн талууд бий болох юм.

Ө.Сувдаа: Дээрх аудитын тайланг сонсоход 2023 оны жилийн эцсийн байдлаар 640 зээлдэгч дотор төрийн албан хаагчид байна уу.

М.Мөнхзул: Сангийн хөрөнгөөс зээл авсан төрийн албан хаагчид байгаа нарийвчилсан тоо гаргаагүй, мөн хамаарал бүхий этгээдийн нэр дээр гарсан зээлүүд байсан. Нэг бүрчлэн энэ чиглэлээр тулган баталгаажуулалтыг бол аудит хийх хугацаанд хийх боломжгүй байсан.

Т.Одсүрэн: Эхний ээлжид Зээлийн мэдээллийн сангийн системд бүртгэлтэй зээлдэгч нарийн мэдээллийг санхүүгийн тайлангийн дүнтэй зээлдэгч тус бүрээр тулган баталгаажуулж зөрүүг арилгаж ТЕЗ-ийн санхүүгийн нэгдсэн тайланд бүртгэлтэй зээлийн авлагын дүнг бодитоор тайлагнуулах нь чухал байгаа учир нь сумдын ХХС-ийн санхүүгийн тайланд бүтгэлтэй авлагын дүнг харилцагч тус бүрээр бус бөөн дүнгээр бүртгэж санхүүгийн тайлан мэдээг буруу тайлагнасан алдааг залруулах шаардлагатай дараагаар нь хугацаа хэтэрсэн зээлийн авлагын дүнг бууруулах сангийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх нь чухал гэж дүгнэж байна.

Н.Лхагвадорж: Сангийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд аудитын тайлан, хорооны дүгнэлтийг олон нийтэд мэдээлэх замаар тус сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналтын системийг сайжруулах чиглэлээр олон нийтийн хяналтад давхар оруулаад ажиллах нь үр дүнтэй болох байх.

Гишүүд: Саналыг дэмжиж байна.

Гишүүд: Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгон хорооны тогтоолоор хяналт шалгалтын дүгнэлтийг хэвээр үлдээхийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

### **3. Шилэн дансны тухай хуулийн 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүнгийн тухай**

Т.Одсүрэн: Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар "Шилэн дансны тухай" хууль, Загийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 127 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн мэдээлэл байршуулалтад нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар нийт **5,687** мэдээлэл байршуулахаас **4,816** мэдээлэл байршуулж **871** мэдээллийг огт байршуулаагүй, **172** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, **18** мэдээллийн цэсийг сонгож нээгээгүйгээс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж **81.7** хувьтай тайлагнагдсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан "үнэн зөв, бодиттой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-6.5 заасан хугацааг хоцроосон, огт мэдээлээгүй зөрчил оршоор байна.

Иймд ТЭЗ-ийн харьяа байгууллагуудаас шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай ОНӨААТҮГ-ын 1, ТТЗ-ийн 12, ТШЗ-ийн 6 нийт 19 байгууллагын 38 эрх бүхий албан тушаалтанд улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж хуулийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авах саналтай байна.

Гишүүд: Шилэн дансны мэдээлэл байршуулалтын 2024 оны 1 дүгээр улирлын үр дүн 81.7 хувьтай гарсан тул "**Сайжруулах шаардлагатай**" гэсэн дүгнэлтийг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж дараах Төсвийн

төвлөрүүлэн захирагч, Төсвийн шууд захирагч, ОНӨААТҮГ-ын захирал нарт албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлэхээр дэмжив.

**4. Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийсэн Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай**

Т.Одсүрэн: Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын эрсдэлийн үнэлгээгээр “Бага” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн гаалийн бүрдүүлэлт, эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэсэн дүгнэлт гарсан.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд тайлагнахыг Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Өнөболдод хариуцуулсан болно.

Гишүүд: Дотоод аудитын хорооны тогтоолыг аудитын тайлан, санхүүгийн хяналт шалгалтын танилцуулга, ажлын баримтуудын хамт Сангийн Яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт болон холбогдох албан тушаалтанд хүргүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгох нь зүйтэй гэж хорооны гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж тогтоолын төслийг батлахаар санал нэгдэв.

**5. Иргэнээс Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ойн хандивын зарцуулалтай холбоотой гаргасан гомдолд дурдсан асуудлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай**

Т.Одсүрэн: Иргэн Д.Чимэдрэгзэнгийн Авлигатай тэмцэх газарт Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ойг тэмдэглэхтэй холбогдуулан нийтийн хандиваар эд материал, бэлэн, бэлэн бусаар 500.0 орчим сая төгрөгийн хандив цугласан бөгөөд тус арга хэмжээнд цугласан хандиваар тусад нь наадам хийх байсныг Мандал сумын 56.0 сая төгрөгийн төсөвтэй наадамтай нийлүүлэн хийснээр тус арга хэмжээг далимдуулан хэд хэдэн эрх мэдэлтэн, албан тушаалтнууд үгсэн хуйвалдаж ард иргэдийн хандивын хөрөнгөөр хийсэн баяр наадмын мөнгийг шамшигдуулсан гэж үзэж байгаа тул Хэрх тосгоны нягтлан бодогч М.Соёл-Эрдэнийг шалгуулах гомдлыг гаргасан байна.

1.4. Дээрх дурдсан гомдолтой холбоотойгоор санхүүгийн хяналт шалгалтыг дараах асуудлын хүрээнд шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд.

- ✓ *Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхэд 500.0 орчим сая төгрөгийн нийтийн хандив цугласан эсэх.*
- ✓ *Нийтийн хандиваар цугларсан хөрөнгийн зарцуулалт, түүнийг олон нийтэд тайлагнасан эсэх.*

- ✓ Хэрх тосгоны нягтлан бодогч М.Соёл-Эрдэнэ нь ойн арга хэмжээнд оролцсон үүрэг, ард иргэдийн баяр наадмын хандивын хөрөнгийг хувьдаа шамшигдуулсан эсэх.

№	Эх үүсвэрийн төрөл	Мөнгөн дэмжлэг			Мөнгөн бус хандив, хөрөнгө оруулалт	Нийт дүн /мянган төгрөгөөр/
		Орон нутгийн төсөв	Хандив-харилцах	Хандив-Бэлэн мөнгө		
1	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас	10,000.00				10,000
2	Мандал сумын ОНХС	9,750.00				9,750
3	ААНБ, нөхөрлөл, холбоо, иргэн		231,940.00	74,110.00		306,050
4	Даага				3	
5	Хонь				11	
6	Ямаа				11	
7	Мотоцикл				3	
	дүн	19,750.00	231,940.00	74,110.00	28.00	325,800.00
4	Мандал сумын ОНХС-аас Түнхэл тосгоны баяр наадмын зардалд	3,000.00				3,000
5	Мандал сум баяр наадмын зардал ОНХС-аас зарцуулах	40,250.00				40,250
6	Ж.Эрдэнэбат /УИХ-ын гишүүн/				100,000.0	100,000.0
	дүн	43,250.00	-	-	100,000.0	143,250.00
	Бүгд дүн	63,000.00	281,940.00	74,110.00	60,028.00	469,050.00

Баяр наадмын арга хэмжээнд цугласан хандив тусламжийн орлогын зарцуулалтыг хяналт шалгалтын явцад тулган баталгаажуулахад илэрсэн санхүүгийн зөрчил дутагдал нь ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн ажил үүргийн уялдааг хангаагүй, бүтээн байгуулалт, баяр наадмын бэлтгэл ажлыг хийхэд шаардлагатай төсвийн тооцоо судалгааг урьдчилан хийж ажлын хэсгээр хэлэлцүүлэн шаардагдах төсвийг батлан гүйцэтгэлд хяналт тавих процессыг хэрэгжүүлээгүйн улмаас дээрх зөрчил дутагдал гарсан байна.

Ойн баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийтийн хандив тусламжийн орлого, зарцуулалт, хийсэн ажлын тайланг иргэд олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Мандал сумын Хэрх тосгоны 100 жилийн ой тэмдэглэх хүрээнд эд материал болон бэлэн, бэлэн бусаар цугларсан мөнгөн хандивын зарцуулалтын тайлан, төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, санхүүгийн баримтуудыг хамруулан санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд нийт **154,779.7** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,291.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 153,488.3 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж гомдол гаргагчид хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн хяналт шалгалтын дүн олон нийтэд мэдээлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Гишүүдээс гомдлын мөрөөр хэрэгжүүлсэн хяналт шалгалтын дүнтэй холбоотой гарсан санал хүсэлт гараагүй болно.

**6. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц орон тоонд өөрчлөлт оруулах саналын танилцуулга,**

Т.Одсүрэн: Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Дотоод аудитын дүрэмд “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоод аудитын үйл ажиллагааг стандарт, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах” үүрэг хүлээсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дүгээр сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дэх зорилтод Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ гэж заасан байдаг.

Сангийн яамнаас Улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг төв, орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, Дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх, Дотоод аудитын бие даасан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны засаглалыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023-2025 онд хэрэгжүүлэх “Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг” боловсруулан баталсан.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт, төсвийн зарлага, төсөл арга хэмжээний тоо, төрийн үйлчилгээг ард иргэдэд үзүүлэх төрийн болон орон нутгийн байгууллагын тоо нэмэгдэж түүнийг дагаад хяналт шалгалтын объект, цар хүрээ төсвийн зарцуулалт жил ирэх тусам нэмэгдэж байхад 2014 оноос Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албадыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасны дагуу байгуулснаас хойш бүтэц орон тоонд оновчтой өөрчлөлт ороогүйгээс хяналт, шалгалтын ажлын ачаалал ихсэж, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирсан.

Мөн Дотоод аудитын олон улсын стандартад нийцүүлэн Улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааг хөгжүүлэх төв, орон нутагт чанарын нэгдсэн түвшинд хүргэх, хараат бус байдал, чадавхыг бэхжүүлж төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны засаглалыг бэхжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжийн Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд сүүлийн жилүүдэд хяналт шалгалтын ажлын ачаалал нэмэгдэхээс гадна хүний нөөцийн дутагдал орсонтой холбоотойгоор санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц орон тоо, албан

тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, өөрчлөлт оруулах замаар хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин, урамшууллын зохистой тогтолцоог бүрдүүлэн дотоод аудиторын авлига, ашиг сонирхлын зөрчилд ертөхөөс урьдчилан сэргийлэх, шалгагдагч байгууллагуудтай харилцахад албан тушаалын статусыг ахиулах замаар тус нэгжийн санхүүгийн хяналт, дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Энэхүү Захирамжид нэмэлт өөрчлөлт орж батлагдсанаар Төсвийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар хүлээсэн Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлсэн хараат бус бие даасан хяналтын тогтолцоог орон нутагт хэрэгжүүлж улс, орон нутгийн төсөвт тавих хяналтыг сайжруулах эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд тус албан бүтцийг санхүүгийн хяналт, дотоод аудитын нэгжийн бүтэц дотор одоо мөрдөгдөж байгаа орон тоог улсын ахлах байцаагч 1, ахлах мэргэжилтэн 2, жолооч-нярав гэсэн орон тоог шинээр нэмж батлуулах саналтай байна.

Н.Лхагвадорж: Гишүүд саналаа хэлнэ үү.

Ө.Сувдаа: Тус орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төсөв зарлага цалингийн зардал хэдээр нэмэгдэхээр тооцоолол хийсэн бэ?.

Т.Одсүрэн: Шинээр 4 орон тоо нэмэгдэхэд сүүлийн хагас жилийн цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 70.4 сая төгрөг шаардагдах тооцоо гарсан.

Ө.Сувдаа: Хэрэв орон тоог нэмж баталсан тохиолдол дээрх зардлыг шийдвэрлэхэд хүндрэл байхгүй боломжтой гэж үзэж байна. Харин ажлын байрны өрөө, тасалгааны хувьд 2024 ондоо шийдвэрлэх боломжгүй тул танай алба энэ тал дээр өөрсдөө зохицуулах арга хэмжээг аваарай 2025 онд шинээр баригдаж ашиглалтад орон захиргааны барилгаас тус асуудлыг шийдвэрлэх боломж байгааг хэлэх нь зүйтэй байна.

Т.Одсүрэн: Орон тооны асуудал нь өөрөө нэг өдөр шууд шийдэх боломжгүй цаг хугацаа орсон асуудал байдаг. Өөрөөр хэлбэл батлагдлаа гээд маргааш нь сонгон шалгаруулаад шалгуур хангасан хүн ороод ирэхгүй болохоор эхний ээлжид сууриа бэлтгэхэд тус шийдвэр гол ач холбогдолтой байгааг дурдах нь зүйтэй байна.

Т.Мөнхзул: Манай албанаас бүтэц орон тоонд оруулах саналыг боловсруулахдаа сангийн яамнаас баримталж байгаа бодлого нь санхүүгийн хяналт, дотоод аудитын чиг үүргийг аль аль асуудлыг орхигдуулахгүй байхад анхаарч улсын салбарын дотоод аудитыг олон улсын стандартад хүргэн хөгжүүлэх чиглэлд анхаарч Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/1211 дугаартай албан бичигт Сүүлийн жилүүдэд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албадын орон тоо, төсөв хүрэлцээгүйгээс хяналт, шалгалтын ажлын ачаалал ихсэж, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирч

байгаа тул тус албаны төсөв, орон тоо, үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахыг аймгийн засаг дарга нарт ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр оруулсан юм.

Сувдаа: Дээрх асуудлын өмнөх хуралдаанаар зарчмын хувьд дэмжсэн бөгөөд цаг үеийн байдлаас шалтгаан шийдвэрлээгүй байсан тул бүтэц, орон тооны саналыг тус албанаас гаргасан томъёоллын дагуу 4 орон тоогоор нэмэгдүүлж 12 байхаар дэмжихэд татгалзах зүйлгүй.

А.Дашбат: Орон тоог нэмэгдүүлснээр хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хяналт шалгалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд мэргэжлийн ур чадвар, туршлага хүлээн зөвшөөрөгдсөн албан хаагчийг сонгон шалгаруулж авахад анхаарах шаардлагатай саналыг дэмжиж байна.

Х.Мөнхжаргал: Хяналт шалгалтын ажилтныг сонгох тал дээр А.Дашбатын саналтай нэг байна. Учир нь шалгагдагч байгууллагын зүгээс мэдлэг чадвар, туршлага муутай хүнээр шалгуулах дургуй байдагтай холбоотойгоор танай байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тул үүн дээрээ албаны дарга хариуцлагатай ажиллах нь зүйтэй байх.

Т.Одсүрэн: Дотоод аудитын хорооноос бидний ажлын үнэ цэнийг нэмэгдүүлэх албаны үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж бодлогын түвшинд шийдвэр гарган ажилласан ба бүхэндээ баярлаж талархсанаа илэрхийлье

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагаанд **"Хангалттай"** гэж дүгнэв..
2. Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил нь "Их" эрсдэлтэй байгаа тул сангийн хөрөнгийн ашиглалтыг **"Хангалтгүй"** гэж дүгнэв.
3. Шилэн дансны тухай хуулийн 2024 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүнд үндэслэж 19 байгууллагын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг **"Сайжруулах шаардлагатай"** гэж дүгнэж дараах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:
  - ✓ Шилэн дансны тухай хуулийн 8.4-т "Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.
  - ✓ Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан **"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"** 8.1-д заасан Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнаж байх.
  - ✓ Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ сайжруулах.

4. Сангийн яамны нэгдсэн удирдамжаар хийсэн Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүн эрсдэлийн үнэлгээгээр "Бага" эрсдэлтэйд тооцов.
5. Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц орон тоонд оруулах өөрчлөлтөөр ТЗ-6 Улсын ахлах байцаагч 1, ТЗ-7 дотоод аудитор 2, ТҮ-4 нярав- жолооч гэсэн нийт 4 орон тоогоор тус тус нэмэгдүүлэхээр дэмжиж шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ДАРГА



Н.ЛХАГВАДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  
АХЛАХ ДОТООД АУДИТОР

Т.МӨНХЗУЛ